

Маргааны товч

Нэхэмжлэгчээс “... Яруу сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 06 дугаар сарын 05-ны өдрийн 13 дугаар тогтоолыг хүчингүй болгуулах” нэхэмжлэлийн шаардлага гаргаж, үндэслэлээ “... Засгийн газрын тогтоолоор ашигт малтмалын хайгуулын талбайн солбилцолыг баталсан байтал нэхэмжлэгчийн тусгай зөвшөөрлийн талбайтай давхцуулан орон нутгийн тусгай хэрэгцээнд авсан нь хууль бус, Ашигт малтмалын тухай хуульд заасан хайгуул хийх эрхийг хязгаарласан, хэм хэмжээний актад бүртгэгдээгүй ...” гэж тайлбарлан маргажээ.

Хариуцагчаас “... Орон нутгийн тусгай хамгаалалтад авсан газрыг Ашигт малтмал, газрын тосны газрын Кадастрын хэлтсийн даргын 2023 оны 07 дугаар сарын 04-ний өдрийн 10/339 дүгээр шийдвэрээр бүртгэлийн системд бүртгэсэн, тусгай хэрэгцээнд авсны дараа ... Кадастрын хэлтсийн даргын 2023 оны 08 дугаар сарын 08-ны өдрийн 289 дүгээр шийдвэрээр ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрлийн эрх эзэмших болсон нь иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 13 дугаар тогтоолыг зөрчиж байна” гэж нэхэмжлэлийг эс зөвшөөрсөн хариу тайлбар гаргажээ.